



Сүхбаатар аймаг дахь Төрийн
аудитын газар

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН
ТАЙЛАН ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: 2022/01/НА-СТА-ТЕЗ

Баруун-Урт хот 2022 он



Газрын дарга, тэргүүлэх аудитор **М.Нарантуяа**
Утас: 700518369 Цахим хаяг: Narantuyam@audit.gov.mn
Аудитын менежер Г.Даваа
Утас: 70512123 Цахим хаяг: Davaag@audit.gov.mn
Ахлах аудитор Н.Болдбаатар
Утас: 70512127 Цахим хаяг: Boldbaatar@audit.gov.mn
Аудитор Б.Мөнхбамбар
Утас: 70512127 Цахим хаяг: Munkhbambar@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	4
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	5
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	7
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	8
3.1. Аудитын тайлан.....	9
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	9
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналт.....	10
3.4 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	10
3.5. Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн.....	10
3.5.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө.....	10
3.5.2 Авлага.....	12
3.5.3 Бараа материал.....	13
3.5.4 Урьдчилгаа.....	14
3.5.5 Үндсэн хөрөнгө.....	14
3.5.6 Өр төлбөр.....	16
3.5.7 Засгийн газрын хувь оролцоо.....	18
3.5.8 Орлогын данс.....	19
3.5.9 Зардал.....	20
3.6 Төсвийн гүйцэтгэлийн ТАЛААР ТАЙЛБАР, ТОДРУУЛГА.....	21
3.7 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	22
3.8 Зөрчил дутагдлыг нэгж бүрээр нь авч үзвэл.....	23
3.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	25
3.10 Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн хүрээнд авч үзсэн асуудал.....	25
3.11. Шилэн дансны мэдээлэл.....	28
3.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	28
3.13. Аудитын зөвлөмж.....	28
3.13. Холбогдох байгууллагын санал:.....	30
3.14. аудитын тайлан баталагаажуулсан тушаал:.....	33
4.1 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	0
4.2 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл.....	0

1. Аудитын гэрчилгээ



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2021.04.29 № 225
танай _____-ны № _____-г

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Сүхбаатар аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Сүхбаатар аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар материаллаг шинжтэй 2,578.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн бөгөөд УСНББОУС болон холбогдох хууль, журамд нийцээгүй, иж бүрэн байх, эрх ба үүрэг зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
		/Мянган төгрөг/	
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	20,854,687.50	32,406,624.70
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	9,408,301.60	16,144,818.80
33	АВЛАГА	5,611,416.40	7,143,919.40
34	УРЬДЧИЛГАА	143,339.80	175,450.20
35	БАРАА МАТЕРИАЛ	5,563,507.20	8,814,593.40
36	НӨӨЦИЙН БАРАА	65,802.20	14,172.70
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	62,320.30	113,670.30
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	105,205,416.80	122,232,469.90
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	105,205,416.80	122,232,469.90
39200	Биет хөрөнгө	100,933,577.60	117,599,594.70
39300	Биет бус хөрөнгө	4,262,118.90	4,622,684.90
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	9,720.30	10,190.30
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	126,060,104.30	154,639,094.60
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	27,595,825.80	29,600,335.20
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	20,757,976.50	22,308,696.10
41200	Богино хугацаат зээлийн өглөг	1,221,536.20	1,109,940.40
41300	Өглөг	2,261,563.60	1,811,744.10
41400	Урьдчилж орсон орлого	17,274,876.60	19,387,011.60
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,837,849.30	7,291,639.10
42200	Урт хугацаат зээл	6,837,849.30	7,291,639.10
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	98,464,278.50	125,038,759.50
51	Засгийн газрын хувь оролцоо	98,464,278.50	125,038,759.50
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	59,343,906.00	59,804,658.30
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	990,669.30	1,006,066.30
51102	Өмч /хувийн/ /ТӨҮГ/	820.3	820.3
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	231,207.20	236,956.00
51200	Хуримтлагдсан үр дүн	12,967,069.00	38,997,199.40
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	24,930,606.70	24,993,059.30
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	126,060,104.30	154,639,094.60

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
		/Мянган төгрөг/	
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	97,862,125.40	129,720,900.10
11	ТАТВАРЫН ОРЛОГО	9,051,984.90	14,169,804.20
110	Орлогын албан татвар	6,692,489.30	8,505,214.30
1100	Хувь хүний орлогын албан татвар	7,157,374.10	8,862,611.20
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-464,884.80	-357,396.80
113	Хөрөнгийн албан татвар	1,061,949.50	2,823,608.60
118	Бусад татвар, төлбөр, хураамж	1,297,546.10	2,840,981.30

12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	78,844,989.60	99,527,943.10
120	Нийтлэг татварын бус орлого	23,828,986.70	41,366,136.00
121	Хөрөнгийн орлого	46,754.50	52,854.40
122	Тусламжийн орлого	7,394.00	38,300.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	54,961,854.40	58,070,652.70
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	9,965,150.90	16,023,152.80
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	76,833,366.90	87,920,656.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	76,833,366.90	87,920,656.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	70,906,020.10	84,048,251.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	32,168,781.80	34,841,310.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,057,381.00	4,499,422.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,390,909.40	5,399,360.80
2104	Хангамж, бараа материалын зардал	9,543,561.80	9,196,482.60
2105	Нормативт зардал	2,302,973.00	3,105,949.80
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	516,449.50	972,416.60
2107	Томилот, зочны зардал	89,222.60	126,702.60
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,665,400.00	9,716,003.30
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,171,341.10	16,190,603.00
212	ТАТААС	500	0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,926,846.80	3,872,404.30
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	21,028,758.50	41,800,244.00
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	10,235.40	500
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	10,850,009.00	15,265,064.20
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	10,188,984.90	26,535,679.80

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	88,228,577.20	88,228,577.20
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	246,558.90	246,558.90
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	88,475,136.20	88,475,136.20
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-242,885.30	-242,885.30
7	Өмчид гарсан өөрчилөлт	43,042.70	43,042.70
9	Тайлант үеийн үр дүн	10,188,984.90	10,188,984.90
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	98,464,278.50	98,464,278.50
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	98,464,278.50	98,464,278.50
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	791,257.80	791,257.80
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	99,255,536.40	99,255,536.40
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-137,717.60	-137,717.60
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	12,804.00	12,804.00
17	Өмчид гарсан өөрчилөлт	21,745.80	21,745.80
19	Тайлант үеийн үр дүн	26,535,659.80	26,535,659.80
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	125,038,759.50	125,038,759.50

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	92,118,962.60	110,874,258.20
11	ТАТВАРЫН ОРЛОГО	9,049,984.70	14,090,451.90
110	Орлогын албан татвар	6,690,489.30	8,425,862.00
1100	Хувь хүний орлогын албан татвар	7,155,374.10	8,783,258.90
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-464,884.80	-357,396.80
113	Хөрөнгийн албан татвар	1,061,949.50	2,823,608.60
118	Бусад татвар, төлбөр, хураамж	1,297,545.90	2,840,981.30
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	294,780.30	376,840.50
1181	Газрын төлбөр	472,932.20	706,056.70
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	508,393.80	1,725,336.00
1183	Бусад татвар	21,439.60	32,748.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	73,058,419.70	83,326,837.20
120	Нийтлэг татварын бус орлого	18,042,416.80	25,200,030.10
121	Хөрөнгийн орлого	46,754.50	52,854.40
122	Тусламжийн орлого	7,394.00	3,300.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	54,961,854.40	58,070,652.70
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,010,558.20	13,456,969.20
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	67,440,713.50	80,919,965.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	67,440,713.50	80,919,965.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	63,932,458.50	78,557,929.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	34,925,453.50	37,600,215.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,963,545.40	5,435,117.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,522,174.80	6,489,948.90
2104	Хангамж, бараа материалын зардал	5,776,377.80	7,149,044.40
2105	Нормативт зардал	2,365,092.60	2,793,399.80
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	578,300.30	1,051,019.60
2107	Томилот, зочны зардал	91,051.60	129,686.40
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,334,175.50	8,406,481.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,376,286.90	9,503,016.10
211	ХҮҮ	0	0
212	ТАТААС	500	0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,507,755.10	2,362,036.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	24,678,249.00	29,954,292.60
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	28,862.00	19,682.60
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	19,371,564.90	22,364,821.50
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	19,371,564.90	22,364,821.50
2200	Дотоод эх үүсвэрээр	19,371,564.90	22,364,821.50
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-19,342,703.00	-22,345,139.00

VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-929,614.80	-872,636.40
14	Бусад эх үүсвэр	38,000.00	19,045.20
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	824,550.00	854,568.00
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	143,064.80	37,113.60
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	4,405,931.30	6,736,517.30
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,002,370.20	9,408,301.60
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,408,301.60	16,144,818.80

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Баглагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	81,225,526.9	72,555,608.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	59,110,382.1	56,687,856.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	57,316,287.0	55,040,581.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	33,745,457.1	33,039,736.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,440,311.8	4,298,062.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,464,263.0	5,223,870.3
2104	Хангамж, бараа материалын зардал	1,275,906.5	1,220,133.5
2105	Нормативт зардал	1,554,679.4	1,485,105.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,394,429.9	1,260,950.5
2107	Томилолт, зочны зардал	153,784.4	121,470.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,347,530.9	3,147,443.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,939,924.0	5,243,809.2
212	ТАТААС	257,233.8	245,233.8
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	107,233.8	107,233.8
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	150,000.0	138,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,536,861.3	1,402,041.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,536,861.3	1,402,041.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	20,155,529.3	15,013,183.3
2200	Дотоод эх үүсвэрээр	20,155,529.3	15,013,183.3
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1,959,615.5	854,568.0
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	81,225,526.9	76,341,309.7
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	49,152,802.5	48,878,614.8
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	26,333,212.3	24,370,828.7
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	426,319.3	255,038.2
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,313,192.8	2,836,828.1
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	2,995,658.7
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	6,781,360.3

61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	102	102
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	2860	2794
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	17710	16919
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	11419	10895
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	6291	6024
64	ЭМЧЛҮҮЛЭГСДИЙН ТОО	4518	3024
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	2860	2794

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/Мянган төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны Гүйцэтгэл	Тайлант оны Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,044,677.2	6,693,455.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,005,127.2	6,693,455.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,031,734.7	5,907,937.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	92,835.9	685,168.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,306.8	78,986.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,968.8	77,161.3
2104	Хангамж, бараа материалын зардал	129,559.3	291,216.4
2105	Нормативт зардал	120,735.6	1,007,932.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	167,838.0	436,832.7
2107	Томилолт, зочны зардал	13,587.3	5,977.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,006,988.3	1,574,821.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,474,914.6	1,749,840.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	973,392.5	785,518.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	973,392.5	577,685.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	39,550.0	-
2200	Дотоод эх үүсвэрээр	39,550.0	-
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,044,677.2	6,748,734.5
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,044,677.2	6,748,734.5
	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		55,278.9
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		55,278.9

3.1. Аудитын тайлан

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Сүхбаатар аймгийн Засаг даргын 2021 санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Засаг дарга М.Идэрбат танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн биологийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүртгэх, тайлагналыг боловсронгуй болгох, аймгийн төвийн төсвийн байгууллагын барилгад дулааны тоолууржуулалт хийх, орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын үйл ажиллагааг сайжруулах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2022 оны 4 дүгээр сарын 01-нээс 4 дүгээр сарын 20-ны хооронд хийж, аудитын тайланг 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, ахлах аудитор Н.Болдбаатар, аудитор Б.Мөнхбамбар нар хариуцаж хэрэгжүүлэв.

Сүхбаатар аймгийн Засаг даргын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг 2022.04.04-нд төрийн аудитын байгууллагад 6/274 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Сүхбаатар аймгийн Засаг даргын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Мал аж ахуйн салбарын хөгжлийг эрчимжүүлж, уул уурхай дагасан дэд бүтцийн хөгжлийг дэмжин, нийгмийн салбаруудын үйл ажиллагааны чанар үр дүнг сайжруулах замаар хувь хүний хөгжил, боловсрол, өрх гэр бүлийн амьдралыг сайжруулах бодлого үйл ажиллагааг түлхүү хэрэгжүүлэх”-д оршино.

Сүхбаатар аймгийн Засаг даргын 2021 оны хөгжлийн төлөвлөгөөний зорилтыг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ковид-19 халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого
- Хүний хөгжлийн бодлого
- Эдийн засгийн бодлого
- Засаглал
- Ногоон хөгжлийн бодлого
- Бүс, орон нутгийн бодлого

Тайлант хугацаанд аймгийн Засаг даргын санхүүгийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар-ыг шинэчлэн батлах тухай
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”

- УИХ-аас “Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль” 2021 оны 6 дугаар сарын 11-нд батлагдаж, 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Сүхбаатар аймгийн Засаг даргын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2009 онд боловсруулсан, нэмэлт өөрчлөлт, стандартын өөрчлөлттэй холбогдуулан шинэчлэн боловсруулаагүй нь санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад заавар, журам, стандартыг мөрдөхгүй байх зэрэг үр дагавартай байна.

Сүхбаатар аймгийн Засаг даргын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

Сүхбаатар аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба 2021 онд аймгийн Засаг даргын харьяа төсвийн шууд захирагч, ОНӨААТҮГ-ын нийт 54 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт, 32 объектын үйл ажиллагаанд дотоод аудит, иргэний 6 өргөдөл гомдол ирсний 3 өргөдөлтэй холбогдуулан 2 байгууллагад санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг гүйцэтгэжээ.

Хяналт шалгалтаар нийт 1,270.6 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 273.7 сая төгрөгийн 72 акт тогтоож, 996.9 сая төгрөгийн 52 албан шаардлага өгч, зөрчлийг арилгах 121 заалт бүхий 30 зөвлөмжийг өгсөн байна. Төлбөрийн актын биелэлт 13.0 хувь, албан шаардлагын биелэлт 74 хувь, өгсөн зөвлөмжийн биелэлтийг хангаж ажилласан байна.

3.4 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Сүхбаатар аймгийн Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн нийт хөрөнгийг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшинг аймгийн Засаг даргын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн нийт хөрөнгө 154,639.1 сая төгрөгийн 1.5 хувь буюу 2,319.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар 1,739.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

3.5. Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн

3.5.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 9,408.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 16,144.8 сая төгрөг болж, 6,736.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	10.4	7.5	-2.9
Банканд байгаа бэлэн мөнгө	9,379.9	16,137.3	6,757.4
Замд яваа мөнгөн хөрөнгө			
Хадгаламж			
Дүн	9,408.3	16,144.8	6,736.5
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	2,995.4	6,836.6	3,841.2
Төсөл/ сан	3,801.5	3,459.6	341.9
Төрийн сан	2,358.7	5,443.4	3,084.7
ТӨҮГ болон ОНӨҮГ	252.4	405.2	152.8
Дүн	9,408.3	16,144.8	6,736.5

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдлийн 6,836.6 сая төгрөг төсөвт байгууллага, 3,459.6 сая төгрөг төсөл сангийн үлдэгдэл, 405.2 сая төгрөг орон нутгийн өмчит байгууллага, 5,443.4 сая төгрөг Төрийн сангийн үлдэгдэл байна.

Төрийн сангийн дансны үлдэгдлийн 5,223.3 сая төгрөг орон нутгийн ерөнхий дансны үлдэгдэл, 5,356.2 сая төгрөг Орон нутгийн хөгжлийн сан, Замын сан, Боловсрол, эрүүл мэндийг дэмжих сангийн үлдэгдэл, 1,391.8 сая төгрөг сум хөгжүүлэх сангийн үлдэгдэл, 308.7 сая төгрөг сумдын эмнэлгүүдийн болон орон нутгийн байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдэл, 3,459.6 сая төгрөг хөрөнгө оруулалтын барьцаа дансны үлдэгдэл байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийн дутуу санхүүжилт 2,600.0 сая төгрөг оны эцэст санхүүжсэн нь төрийн сангийн дансны үлдэгдэл өсөхөд нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

Мөнгөн хөрөнгөтэй холбоотой аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгээгддэг харьяа байгууллагуудад нийт 385.5 сая төгрөгийн 21 алдаа, зөрчил илэрч 5.1 сая төгрөгийн зөрчилд 5 төлбөрийн акт тогтоож, 384.0 сая төгрөгийн зөрчилд 15 албан шаардлага, 1 зөвлөмж өглөө. Үүнд:

- Анхан шатны баримтын иж бүрдэл бүрэн хангагдаагүй ажил үйлчилгээг санхүүгийн тайланд тусгасан, / Халзан сумын Засаг даргын Тамгын газар 0.3 сая, Халзан сумын Эрүүл мэндийн төв 1.5 сая, Түмэнцогт сумын Засаг даргын Тамгын газар 1.5 сая, Сүхбаатар аймгийн ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургууль 0.3 сая төгрөг/
- Ажил гүйцэтгэх гэрээ байгуулан төлбөрийг шилжүүлсэн боловч гэрээ дүгнээгүй, ажил дуусаагүй, актаар хүлээж аваагүй байхад санхүүжилт олгосон /Халзан сумын Орон нутгийн хөгжлийн сан, Дарьганга сумын Орон нутгийн хөгжлийн сан /
- Батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулсан /Наран сумын Орон нутгийн хөгжлийн сан 2.4 сая төгрөг/
- Иргэдийн саналаар дэмжигдсэн төсөл, арга хэмжээг батлуулан, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх. /Баяндэлгэр, Дарьганга, Мөнххаан, Онгон, Уулбаян, Халзан, Эрдэнэцагаан сумдын Орон нутгийн хөгжлийн сан/
- Өвс тэжээлийн нөөцийн агуулах барих төслийн орон нутгийн оролцооны хувийг гэрээнд заасан дүнгээс илүү шилжүүлсэн. / Онгон сумын Орон нутгийн хөгжлийн сан 4.2 сая төгрөг/
- Тоглоомын талбайн засвар төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ төндөр зарлалгүйгээр шууд гэрээ байгуулсан. /Баруун урт сумын Орон нутгийн хөгжлийн сан 40.0 сая төгрөг/
- Төсвийн хөрөнгийг зориулалт бус, үр ашиггүй зүйлд зарцуулсан /Уулбаян сумын Засаг даргын Тамгын газар 3.7 сая, Түвшинширээ сумын Орон нутгийн хөгжлийн сан 0.2 сая төгрөг/
- Төсөл арга хэмжээний төсөвт өртгийг хувааж шууд худалдан авалт хийсэн /Эрдэнэцагаан сумын Орон нутгийн хөгжлийн сан 57.5 сая төгрөг /

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 5,611.4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 7,143.9 сая төгрөг болж, 1,532.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл / сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	50.1	29.9	-20.2
Төлбөртэй үйлчилгээний авлага	114.6	125.9	11.3
Татаас, санхүүжилтийн авлага	0	18.1	18.1
Зээлийн хүүгийн авлага	59.6	48.3	-11.3
Дансны авлага /ТӨҮГ/	1,812.7	2,304.5	491.8
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	64.4	37.8	-26.6
Бусад авлага	3,216.3	4,324.7	1,108.4
Зээлийн авлага	293.7	254.7	-39.0
Дүн	5,611.4	7,143.9	1,532.5
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	3,208.8	4,172.4	963.6
Төсөл/ сан			
Төрийн сан	97.2	97.2	-
ТӨҮГ болон ОНӨҮГ	2,305.4	2,874.3	568.9
Дүн	5,611.4	7,143.9	1,532.5

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлагын 58.4 хувь буюу 4,172.4 сая төгрөг төсөвт байгууллагын, 40.2 хувь буюу 2,874.3 сая төгрөг орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, 1.4 хувь буюу 97.2 сая төгрөг төрийн сангийн авлага байна.

Төсөвт байгууллагын нийт авлагын 63.1 хувийг сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн авлага, 23.6 хувийг эрүүл мэндийн төвүүдийн эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлага байна. Тайлант онд шинээр сум хөгжүүлэх сангаас 1,959.6 сая төгрөгийн зээл олгосон нь нөлөөлсөн байна.

Харин орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд дахь нийт авлагын 24.5 хувь буюу 704.4 сая төгрөг Сүхбаатар үйлдвэр технологийн парк ОНӨААТҮГ-ын зээлийн авлага, 55 хувь буюу 1,574.7 сая төгрөг Дөрвөлж ОНӨААТҮГ-ын авлага эзэлж байна.

Аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт авлагын 3.7 хувь буюу 263.9 сая төгрөг нь олон жилийн насжилттай авлага байна. Эдгээр нь эргэн төлөгдөхгүй байх, төсөвт төвлөрөх эсэх нь эргэлзээтэй, найдваргүй авлага үүсэх нөхцөлийг бий болгосон эрсдэлтэй байна. Олон жилийн насжилттай авлагын 86.4 хувь буюу 228.1 сая төгрөг сум хөгжүүлэх сангийн 2013-2017 онуудад олгосон зээл, зээлийн хүүгийн авлага байна.

Аудитын илрүүлэлт:

Авлагатай холбоотой аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг харьяа байгууллагуудад нийт 564.4 сая төгрөгийн 37 алдаа, зөрчил илэрч 127.8 сая төгрөгийн зөрчилд 17 төлбөрийн акт тогтоож, 61.5 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага, 375.1 сая төгрөгийн алдаа, зөрчилд 15 зөвлөмж өглөө. Үүнд:

- *Өмнөх онуудад үүссэн, эзэн холбогдогч нь тодорхойгүй авлагыг барагдуулаагүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй. /9 төсвийн шууд захирагч, 4 ОНӨААТҮГ-ын 354.4 сая төгрөг/*

- Сум хөгжүүлэх сангаас зээл авсан иргэдийн зээлийн гэрээний хугацаа дууссан боловч зээлийн үндсэн төлөлт, хүүгийн орлогыг гэрээнд заасан хугацаанд төлж барагдуулаагүй /Баяндэлгэр, Дарьганга, Мөнххаан, Уулбаян, Эрдэнэцагаан сум СХСан 129.5 сая төгрөг/
- Төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төсөвт төвлөрүүлээгүй бодит бус авлага үүсгэсэн. /13 төсвийн шууд захирагч 24.8 сая төгрөг/
- Эрүүл мэндийн даатгалын сангаас авлагатай, иргэн, хуулийн этгээдэд ямар нэгэн богино хугацаат өр төлбөргүй байна. Уг төсвийн үлдэгдлийг Төсвийн тухай хуульд заасны дагуу дээд шатны төсөв захирагч болон төсөв батлах эрх байгууллагын шийдвэрээр зарцуулагдахаар байна. /Сумдын Эрүүл мэндийн төв/
- Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж, авлага үүсгэсэн. /Орон нутгийн өмчийн газар 10.7 сая төгрөг/

3.5.3 Бараа материал

Бараа материалын оны эхний үлдэгдэл 5,563.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 8,814.6 сая төгрөг болж, 3,251.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт №3. Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	589.30	766.7	-177.4
Дуусаагүй үйлдвэрлэл	518.1	269.2	248.9
Бэлэн бүтээгдэхүүн	2.6	8.5	-5.9
Хангамжийн материал	4,124.3	4,703.1	-578.8
Биологийн хөрөнгө	-	2,672.9	-2,672.9
Мал амьтад	329.2	394.2	-65.0
Дүн	5,563.5	8,814.6	-3,251.1
Үүнээс, байгууллагын төрлөөр			0.0
Төсөвт байгууллага	4,578.9	7,842.7	-3,263.8
ТӨҮГ болон ОНӨҮГ	984.6	971.9	12.7
Дүн	5,563.5	8,814.6	-3,251.1

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд 12,459.6 сая төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан авч, үнэ төлбөргүй буюу хандиваар 474.8, шилжүүлэн авсан 116.1, бусад 3,617.1 сая төгрөгийн бараа материал нэмэгдэж, 13,416.4 сая төгрөгийн бараа материал зарцуулж, 132.8 сая төгрөгийн бараа материалыг акталж, 26.3 сая төгрөгийн бараа материалыг шилжүүлсэн байна.

Нийт бараа материалын үлдэгдлийн 88.9 хувийг төсөвт байгууллага, 11.1 хувийг ОНӨААТҮГ эзэлж байна.

Бараа материалын дуусаагүй үйлдвэрлэл дансанд Баруун-Урт сумын Ерөнхий боловсролын 4 сургуулийн түрээсийн ном 61.8 сая төгрөг, Баруун-Урт сумын ОНХС-аар хэрэгжсэн дуусаагүй 4 төсөл арга хэмжээний 207.4 сая төгрөг тус тус бүртгэсэн байна.

Харин аймгийн ЗДТГ-т /эргэлтийн бус хөрөнгө/ аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа 8 төсөл арга хэмжээний 2,652.9 сая төгрөг, Сүхбаатар сумын ЗДТГ-т 20.0 сая төгрөгийн биологийн хөрөнгө бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

Бараа материалтай холбоотой нийт 416.5 сая төгрөгийн 33 алдаа, зөрчил илэрч 19.1 сая төгрөгийн зөрчилд 13 төлбөрийн акт тогтоож, 70.8 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 326.6 сая төгрөгийн алдаа, зөрчилд 17 зөвлөмж өглөө. Үүнд:

- Байгууллагын үйл ажиллагаанд ашигласан материалыг зарлага болгохгүйгээр үлдэгдлээр тайлагнаж, үлдэгдлийг буруу илэрхийлсэн /8 төсвийн шууд захирагч 26.8 сая төгрөг/
- Бараа материалыг нэр төрөл тоо ширхгээр орлого зарлага болгож, материалын тайлан гаргаагүй /Уулбаян, Халзан сумдын Эрүүл мэндийн төв 70.8 сая төгрөг/
- Бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгө бүртгэлтэй байна. / Баруун-Урт сумын Ерөнхий боловсролын 4-р сургууль, Асгат сумын Засаг даргын Тамгын газар, Асгат сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 18.2 сая төгрөг/
- Бараа материалын сар бүрийн тайланг тулган шалгахад 8 дугаар сарын эцсийн үлдэгдлийг дараагийн сарын эхний үлдэгдэлд дутуу илэрхийлсэн / Баруун-Урт сумын Уртын гэгээ ОНӨААТҮГ/
- Бараа материалын бодитоор байхгүй байна. /Асгат сумын Засаг даргын Тамгын газар 5.0 сая төгрөг/
- Материалыг тайлангаар зарлага болгоогүй шууд зардалд илэрхийлсэн ба үр дүнгийн тайланд зардал илүү илэрхийлсэн /Мөнххаан сумын Эрүүл мэндийн төв, Мөнххаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал/
- Тооллогын комисс эд хөрөнгө нэг бүрийг бодитой тооллого хийгээгүй, тооллогын дүнг нягтлан бодогчтой тулгаж баталгаажуулаагүй /Түвшинширээ сумын Хүүхдийн цэцэрлэг, Асгат сумын ерөнхий боловсролын дунд сургууль/
- Төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төсөвт төвлөрүүлээгүй материал нөөцөлсөн /13 төсвийн шууд захирагчийн 19.1 сая төгрөг/

3.5.4 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 143.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 175.4 сая төгрөг болж, 32.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4. Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	142.8	150.5	7.7
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	0	24.9	24.9
Цалингийн урьдчилгаа	0.5	0	-0.5
Дүн	143.3	175.4	32.1
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	2.8	0.0	-2.8
ТӨҮГ болон ОНӨҮГ	140.5	175.4	34.9
Дүн	143.3	175.4	32.1

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансанд бүртгэгдсэн 175.4 сая төгрөгийн үлдэгдлээс Уртын гэгээ ОНӨААТҮГ бараа материал бэлтгэхэд 24.9 сая төгрөг, Дөрвөлж ОНӨААТҮГ шугам сүлжээний ажил болон шатахууны картын үлдэгдэл 149.0 сая төгрөг, Сүхбаатар тохижилт ОНӨААТҮГ хөрөнгө бэлтгэсэн 1.5 сая төгрөгийг бэлтгэн нийлүүлэгчид төлсөн урьдчилгаа төлбөр байна.

3.5.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 105,205.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 122,232.5 сая төгрөг болж, 17,027.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж, орон сууц	85,598.3	101,857.1	16,258.8
Хуримтлагдсан элэгдэл	-10,090.1	-13,889.5	(3,799.4)
Тээврийн хэрэгсэл	7,700.0	8,420.3	720.3
Хуримтлагдсан элэгдэл	-5,019.0	-5,191.3	(172.3)
Машин тоног төхөөрөмж	16,958.6	18,886.9	1,928.3
Хуримтлагдсан элэгдэл	-11,112.9	-11,339.8	(226.9)
Тавилга эд хогшил	6,125.3	6,505.9	380.6
Хуримтлагдсан элэгдэл	-4,032.1	-4,444.7	(412.6)
Зам гүүрийн байгууламж	344.1	767.8	423.7
Хуримтлагдсан элэгдэл	-33.1	-68.8	(35.7)
Түүх соёлын дурсгалт зүйл	1,172.8	1,174.6	1.8
Дуусаагүй барилга байгууламж	2,424.5	2,424.5	-
Номын фонд	785.8	792.7	6.9
Бусад үндсэн хөрөнгө	17,422.5	20,308.2	2,885.7
Хуримтлагдсан элэгдэл	-7,311.1	-8,604.1	(1,293.0)
Программ хангамж	115.8	116.6	0.8
Хуримтлагдсан элэгдэл	-70.3	-73.7	(3.4)
Бусад биет бус хөрөнгө	4,228.7	4,591.7	363.0
Хуримтлагдсан элэгдэл	-12.2	-12.0	0.2
Бусад хөрөнгө /ТӨҮГ/	9.7	10.1	0.4
Дүн	105,205.3	122,232.5	17,027.2
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	71,763.4	88,921.40	17,158.0
ТӨҮГ болон ОНӨҮГ	33,441.9	33,311.10	-130.8
Дүн	105,205.3	122,232.5	17,027.2

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт үндсэн хөрөнгийн үлдэгдлийн 72.7 хувь төсөвт байгууллагууд, 27.3 хувь ОНӨААТҮГ-ын хөрөнгүүд эзэлж байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 1,455.8, үнэ төлбөргүй хандиваар авсан 4,431.8, шилжүүлэн авсан 2,686.3, бусад 19,567.4, дахин үнэлгээний нэмэгдэл 9.3 сая нийт 28,150.6 сая төгрөгөөр нэмэгдэж, худалдсан 184.8, балансаас баланст шилжүүлсэн 405.8, акталсан 4,296.7 сая төгрөгөөр хасагдсан байна.

Дуусаагүй барилга байгууламж дансны өмнөх оны үлдэгдэлд өөрчлөлт ороогүй байна. Энэ нь Баруун-Урт сумын 578.0 сая төгрөгийн сувгийн байгууламж улсын комисс хүлээн аваагүй, Биеийн тамир спортын газрын 700 хүний 1,602.5 сая төгрөгийн Спорт цогцолборын барилгын хөрөнгө царцаагдсан ба нийт 2,424.5 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

Үндсэн хөрөнгөтэй холбоотой нийт 2,135.1 сая төгрөгийн 111 алдаа, зөрчил илрүүлснээс 113.6 сая төгрөгийн зөрчилд 13 албан шаардлага, 2,021.5 сая төгрөгийн зөрчилд 98 зөвлөмж өгсөн. Үүнд:

- Тооллогын комисс эд хөрөнгө нэг бүрийг үнэн зөв бодитой тооллого хийгээгүй, тооллогын дүнг нягтлан бодогчтой тулгаж баталгаажуулаагүй /9 төсвийн шууд захирагч/
- Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх

- өртөггүй хөрөнгө бүртгэлтэй байна. /84 төсвийн шууд захирагч, 4 ОНӨААТҮГ/
- Үндсэн хөрөнгө худалдан авахдаа хэрэгцээ шаардлагаа бодитой тодорхойлсон эсэх нь тодорхойгүй, өмч хамгаалах зөвлөлийн шийдвэр болон ИТХ, орон нутгийн өмчийн албаны зөвшөөрөлгүйгээр хөрөнгө худалдан авсан. /Баруун-Урт сумын Засаг даргын Тамгын газар, Сүхбаатар аймгийн ахмадын хороо, Баруун-Урт сумын 9,10 дугаар цэцэрлэг/
 - Эрх бүхий байгууллагын шийдвэрийг гаргуулж, хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй. /Сүхбаатар аймгийн Засаг даргын хөтөлбөр, үйл ажиллагааны зардал, Баруун-Урт сумын 1, 3 дүгээр цэцэрлэг/
 - Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар бий болсон үндсэн хөрөнгийг данс бүртгэлд дутуу бүртгэснийг залруулж, санхүүгийн тайланд үнэн зөв толилуулах /Онгон сумын Орон нутгийн хөгжлийн сан/

3.5.6 Өр төлбөр

Богино хугацаат өр төлбөрийн оны эхний үлдэгдэл 20,757.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 22,308.6 сая төгрөг болж, 1,505.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Богино хугацаат өр төлбөр дүн	20,757.9	22,308.6	1,550.7
Богино хугацаат зээлийн өглөг	1,221.5	1,109.9	-111.6
Өглөг	2,261.6	1,811.7	-449.9
Ажиллагчидтай холбогдсон өглөг	111.1	116.9	5.8
Бараа үйлчилгээний зардлын өглөг	16.0	64.5	48.5
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	2.1		-2.1
Бусад өглөг	2,132.4	1,630.3	-502.1
Байгууллагад төлөх өглөг	1,415.1	1,285.9	-129.2
Хувь хүмүүст төлөх өглөг	113.3	48.1	-65.2
Татварын өглөг /ТӨҮГ/	290.7	190.6	-100.1
НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	33.6	25.6	-8.0
Дансны өглөг /ТӨҮГ/	279.7	80.1	-199.6
Урьдчилж орсон орлого	17,274.8	19,387.0	2,112.2
Бусад урьдчилж орсон орлого	16,598.2	18,710.4	2,112.2
ТӨҮААГ	676.6	676.6	0.0
Урт хугацаат өр төлбөр дүн	6,837.8	7,291.6	453.8
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	6,837.8	7,291.6	453.8
Нийт дүн	27,595.70	29,600.2	2,004.5
Богино хугацаат өр төлбөр дүн	20,757.90	22,308.6	1,550.7
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	872.7	682.2	-190.5
Төрийн сан	30.9	218.1	187.2
ТӨҮГ болон ОНӨҮГ	19,854.30	21,408.3	1,554.0
Үүнээс, байгууллагын төрлөөр	6,837.80	7,291.6	453.8
ТӨҮГ болон ОНӨҮГ	4,394.00	4,394.0	0.0
Төсөвт байгууллага	2,443.80	2,897.6	453.8
Нийт дүн	27,595.7	29,600.2	2,004.5

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн дүн 2,004.5 сая төгрөгөөр өсөхөд ажиллагчидтай холбогдсон өглөг 4.8 сая төгрөг, бараа үйлчилгээний зардлын өглөг 48.1 сая төгрөг урьдчилж орсон орлого 2,112.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Харин байгууллагад төлөх өглөг 129.2, хувь хүмүүст төлөх өглөг 65.2, дансны өглөг /ТӨҮГ/ 199.6, Татвар, НДШ-ийн өглөг /ТӨҮГ/ 108.1 сая төгрөгөөр буурсан байна.

Богино хугацаат өр төлбөрийн 95.9 хувь буюу 21,408.3 сая төгрөг орон нутгийн өмчит хуулийн этгээд, 3.1 хувь буюу 682.2 сая төгрөг төсөвт байгууллагын, 1.0 хувь буюу 218.1 сая төгрөгийг төрийн сангийн өр төлбөр эзэлж байна.

Урьдчилж орсон орлого 2,112.2 сая төгрөгөөр өссөн нь ОНӨААТҮГ-т орон нутгийн өмчийг эзэмшүүлж, СТОУС-ын дагуу орлогын аргаар бүртгэсэн нь богино хугацаат өр төлбөрийг өсөхөд нөлөөлсөн байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд 12 ОНӨААН-тэй холбоотой 17,274.5 сая төгрөгийн урьдчилж орсон орлого бүртгэлтэйгээс тайлант онд 1,523.0 сая төгрөгийн орлогын бууруулах бичилт хийгдэж, 7 ОНӨААН-д 3,635.5 сая төгрөгийн орлого бүртгэгдэж, оны эцэст 19,387.0 төгрөгийн үлдэгдэлтэй байна. Шинээр бүртгэгдсэн хойшлогдсон орлогыг хүснэгтээр харуулбал.

Үүнд:

		<i>Хүснэгт №7</i>
Байгууллагын нэр		Дүн /сая төгрөг/
1	Дөрвөлж ОНӨААТҮГ	1,603.5
2	Сүхбаатар тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ	40.0
3	Сүхбаатар ойжуулалт ОНӨААТҮГ	58.0
4	Түмэнцогт ОНӨААТҮГ	22.9
5	Уртын гэгээ ОНӨААТҮГ	1,072.9
6	Хайлааст голомт ОНӨААТҮГ	568.2
7	Амгалант дэнж УТҮГ	270.0
Нийт дүн		3,635.5

Урт хугацаат өр төлбөрийн оны эхний үлдэгдэл 6,837.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 7,291.6 сая төгрөг болж, 453.8 сая төгрөгөөр өссөн байна.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд:

- Дөрвөлж ОНӨААТҮГ-ын Азийн хөгжлийн банкнаас авсан урт хугацаат зээлийн 4,394.0 сая төгрөгийн өглөгтэй байна. /МОН-1907 гэрээ 2003-2008/ 3,068.3 сая төгрөг, МОН-2301 гэрээ 2011-2013/ 1,325.7 сая төгрөг/
- Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН-3713 төсөл”-ийн хүрээнд “Сүхбаатар аймгийн төвийн цэвэрлэх байгууламж болон бусад туслах үйлчилгээ”-ний ажил гүйцэтгэх дамжуулан зээлдүүлэх гэрээгээр 2,443.7 сая төгрөгийг /L3713-МОН гэрээ №2019/293/ өр төлбөр бүртгэсэн байна.

Тайлант онд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН-3713 төсөл”-ийн хүрээнд “Сүхбаатар аймгийн төвийн цэвэрлэх байгууламж болон бусад туслах үйлчилгээ”-ний ажил гүйцэтгэх дамжуулан зээлдүүлэх гэрээний зээлийн хүү 453.8 сая төгрөгийг нэмж бүртгэсэн байна.

Аудитын илрүүлэлт:

Өр төлбөртэй холбоотой нийт 218.0 сая төгрөгийн 25 алдаа, зөрчил илэрч, 2.6 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 215.4 сая төгрөгийн алдаа, зөрчилд 24 зөвлөмж өглөө. Үүнд:

- Өр төлбөрийг бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, данс бүртгэлд тусгасан /10 төсвийн шууд захирагч, 2 ОНӨААТҮГ, 144.3 сая төгрөг/
- Батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулж, өр төлбөр үүсгэсэн /Асгат, Сүхбаатар, Дарьганга, Эрдэнэцагаан, Наран сумдын Ерөнхий боловсролын сургууль 16.7 сая төгрөг/
- Жилийн эцэст харилцах дансны хуульыг хянаагүйгээс харилцагч байгууллагад ишлжүүлсэн зарим гүйлгээ буцаж, өр төлбөр үүсгэсэн /Баяндэлгэр сумын ерөнхий боловсролын сургууль 21.9 сая төгрөг/
- Өмнөх онуудад үүссэн он удаан жил болсон өр төлбөрийг барагдуулаагүй /Сүхбаатар аймгийн Тохжилт үйлчилгээ ОНӨААТҮГ, Дарьганга Тохжилт үйлчилгээ ОНӨААТҮГ, Сүхбаатар аймгийн Дөрвөлж ОНӨААТҮГ, Сүхбаатар аймгийн Жаахан шарга театр/
- Тайлант онд үүссэн өр төлбөрийг данс бүртгэлд тусгаагүй /Сүхбаатар нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ/
- Сүхбаатар аймагт Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр нийт 3 төсөл арга хэмжээг хэрэгжүүлж, Улсын төсөвт эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээ байгуулсан байна. Үүний нэг нь МУЗГ болон Азийн хөгжлийн банкны хооронд 2002 оны 09-р сарын 05-ны өдөр байгуулсан “Орон нутгийн хотуудын нийтийн аж ахуйн хөгжлийн хоёрдугаар үе шатны MON(SF)-1907”, OL-2301MON-10-тоот гэрээнүүд байна. Уг гэрээний хүрээнд Аймгийн ЗДТГ, Дөрвөлж ОНӨААТҮГ-ын хооронд дамжуулан зээлдүүлэх гэрээ хийгдсэн бөгөөд одоогийн санхүүгийн тайлан дээр толилуулагдсан 4,394,0 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөр юм. Гэтэл Монгол Улсын Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 01-р сарын 27-ны өдрийн 8-3/417 тоот албан бичгээр тус гэрээний дагуу 4.2 тэрбум төгрөгийн хугацаа хэтэрсэн төлбөр, тооцоолсон алданги 25.1 тэрбум төгрөгт хүрсэн талаар мэдэгдэл ирсэн байна. Үүнээс тус байгууллагатай холбоотой УХӨТ-ыг санхүүгийн тайланд бодит үнэ цэнээр толилуулаагүй, үндсэн төлбөр, хүү, алданги төлөх эрсдэлтэй нөхцөл байдал үүссэн байна. /Дөрвөлж ОНӨААТҮГ/

3.5.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 98,464.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 125,038.7 сая төгрөг болж, 26,574.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №8 Засгийн газрын оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн + Буурсан -
Засгийн газрын оруулсан капитал	59,343.90	59,804.7	460.8
Өмч /ТӨҮГ/	991.4	1,006.9	15.5
Эздийн өмчийн бусад хэсэг	231.2	236.9	5.7
Хуримтлагдсан үр дүн	12,967.10	38,997.2	26,030.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	24,930.60	24,993.0	62.4
Дүн	98,464.20	125,038.7	26,574.5
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	79,542.8	104,267.3	24,724.5
Төсөл, сан	3,801.5	3,459.6	-341.9
Төрийн сан	2,241.0	5,322.5	3,081.5
ТӨҮГ болон ОНӨҮГ	12,878.9	11,989.3	-889.6
Дүн	98,464.2	125,038.7	26,574.5

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өссөн нь тайлант үеийн үр дүн нөлөөлжээ.

Орон нутгийн өмч 460.8 сая төгрөгөөр өссөн нь Онгон сумын ЭМТ-ийн 447.9 сая төгрөгийг хөрөнгийг шилжүүлж авсан, ГХБХБГ газар эзэмших эрхийг 12.8 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь нөлөөлсөн байна.

Тайлант онд хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү 62.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Дахин үнэлгээ нэмэгдэхэд 10 төсөвт байгууллага дахин үнэлсэн үндсэн хөрөнгө 146.2 сая төгрөгийн хөрөнгө акталж, Онгон сумын ЭМТ-д 199.9 сая төгрөгийн хөрөнгө шилжиж ирсэн ба Музей анхны үнээ нөхсөн цаашид ашиглах боломжтой 9.2 сая төгрөгийн хөрөнгийг дахин үнэлсэн нь нөлөөлсөн байна.

3.5.8 Орлогын данс

Сүхбаатар аймгийн Засаг даргын 2021 оны орон нутгийн нэгдсэн татварын орлогыг 10,561.5, татварын бус орлогыг 5,083.1, хөрөнгийн орлогыг 50.0 сая нийт 15,694.6 сая төгрөгөөр төлөвлөжээ.

Нэгтгэсэн тайланд татварын орлого 14,090.4, татварын бус орлого 4,495.5, хөрөнгийн орлого 52.8 сая нийт 18,638.7 сая төгрөг төвлөрчээ.

Орон нутгийн нэгдсэн төсвийн татварын орлогын гүйцэтгэл 14,090.4 сая төгрөг буюу 133.4 хувь, татварын бус орлого 4,495.5 сая төгрөг буюу 88.4 хувийн биелэлттэй гарчээ. Нийт дүнгээр татварын болон татварын бус орлогын гүйцэтгэл 18,585.9 сая төгрөг буюу 118.8 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт №9 Төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая.төг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ОРЛОГО	15,644.6	18,585.9	2,941.3	118.8
ТАТВАРЫН ОРЛОГО	10,561.5	14,090.4	3,528.9	133.4
Хүн амын орлогын албан татвар	6,813.5	8,425.8	1,612.3	123.7
Өмчийн татвар	1,720.6	2,292.6	572.0	133.2
Дотоодын бараа ажил үйлчилгээний татвар	440.0	532.0	90.9	120.7
Улсын тэмдэгтийн хураамж	155.7	160.5	4.7	103.0
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	165.3	119.1	-46.2	72.1
Газрын төлбөр	451.8	706.1	254.3	156.3
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	44.5	10.4	-34.1	23.4
Байгалийн нөөц ашигласны төлбөр	565.7	1,755.3	1,189.7	310.3
Бусад татвар	204.4	89.4	-115.0	43.7
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,083.1	4,495.5	-587.6	88.4
Хүү, торгуулийн орлого	1,072.5	1,474.2	401.7	137.5
Түрээсийн орлого		13.3	13.3	100
Бусад орлого	4,010.6	3,008.0	-1,002.6	75.0

Татварын болон татварын бус орлогоос 8 төрлийн орлого 4.7-1,189.7 сая төгрөгөөр давж, 4 төрлийн орлого 46.7-1,002.6 сая төгрөгөөр тасарсан. Татварын болон татварын бус орлогын давсан, тасарсан шалтгааныг Төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитын дүгнэлтээс үзнэ үү.

Аудитын илрүүлэлт:

Орлого данстай холбоотой нийт 133.9 сая төгрөгийн 9 алдаа, зөрчил илэрч, 133.9 сая төгрөгийн зөрчилд 5 төлбөрийн акт тогтоож, 4 зөрчилд зөвлөмж өглөө. Үүнд:

- Малчин болон мал бүхий иргэдээс малын тоо толгойд ногдуулсан татварыг дутуу төвлөрүүлсэн. /Дарьганга сумын Засаг дарга 32.2 сая, Мөнххаан сумын Засаг дарга 26.1 сая, Эрдэнэцагаан сумын Засаг дарга 62.2 сая төгрөг/
- Ковид-19 цар тахлын үед ард иргэдээс бэлнээр өгсөн хандив тусламжийг төсвийн харилцах дансанд төвлөрүүлээгүй / Уулбаян сумын ЭМТ 3.6 сая төгрөг/
- Коронавирус халдварын шинжилгээний төлбөр харилцах дансанд бүрэн төвлөрүүлээгүй /Халзан сумын ЭМТ 9.9 сая төгрөг /

3.5.9 Зардал

Бараа үйлчилгээний зардал өмнөх оноос 18.5 хувь буюу 13,142.3 сая төгрөгөөр өсөж, урсгал шилжүүлгийн зардал 34.7 хувь буюу 2,054.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №10 /сая.төг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн + Буурсан -
Бараа, ажил үйлчилгээний зардал	70,906.0	84,048.3	13,142.3
Татаас	0.5	-	-0.5
Урсгал шилжүүлэг	5,926.8	3,872.4	-2,054.4
Дүн	76,833.3	87,920.7	11,087.4
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	66,641.2	68,978.5	2,337.3
Төсөл, сан	3,839.7	10,463.2	6,623.5
Төрийн сан	-	111.4	111.4
ТӨҮГ болон ОНӨҮГ	6,352.4	8,367.6	2,015.2
Дүн	76,833.3	87,920.7	11,087.4

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа үйлчилгээний зардлын өсөлт нь Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангахтай холбогдон ариутгалын бараа материал худалдан авсан болон үнэ төлбөргүй олгосон материалын зарцуулалт гол нөлөөлөл үзүүлжээ.

Аудитын илрүүлэлт:

Зардал данстай холбоотой нийт 505.1 сая төгрөгийн 93 алдаа, зөрчил илэрч 39.1 сая төгрөгийн зөрчилд 28 төлбөрийн акт тогтоож, 417.7 сая төгрөгийн зөрчилд 40 албан шаардлага, 48.3 сая төгрөгийн алдаа, зөрчилд 25 зөвлөмж өглөө. Үүнд

- Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас тайлант онд хийгдэхээр төлөвлөгдсөн ойг нөхөн сэргээх, байгалийн сэргэн ургалтыг дэмжих, ойжуулах, ойн зурвас байгуулах ажлыг 2022 онд гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан, шууд зардалд илэрхийлж, төсвийн гүйцэтгэлийг илүү тайлагнасан. /Байгаль орчин, аялал жуулчлалын газар 5.0 сая төгрөг/
- Төсөвт байгууллагын барилгад дулааны тоолуур суурилуулж, дулааны эрчим хүчний төлбөрийг Эрчим хүчний зохицуулах хорооны 2021 оны 10 сарын 14-ний өдрийн 461 дүгээр тогтоолоор батлагдсан “Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф”-ыг мөрдөж, Засгийн газрын 2020 оны 144 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллах. /10 төсвийн шууд захирагч/
- Гадна гэрэлтүүлгийг он дамжуулан хийлгэхээр гэрээ байгуулж, спортын заалны шал, ханыг будахаар будаг худалдан авсан боловч ковид цар тахлаас шалтгаалж будаг хийгдээгүй. /Биеийн тамир спортын газар 21.7 сая төгрөг/
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор хориглосон хөрөнгө бэлтгэсэн, төсвийн хөрөнгийг үр ашиггүй үрэлгэн зарцуулсан. / 25 төсвийн шууд захирагч, 1 ОНӨААТҮГ 310.7 сая төгрөг/
- Материал, ажил үйлчилгээ худалдан авч хоорондын тооцооны дансаар бүртгээгүй шууд зардлаар бүртгэн тайлагнасан. /Мөнххаан, Уулбаян сумдын Засаг даргын Тамгын газар 44.6

сая төгрөг/

- Сургалтын удирдлагын “moodle sols” системийг сургалт хийх зардлын хамт 5.0 сая төгрөгөөр “ICT” компанитай гэрээ байгуулж худалдан авсан. Гэтэл Боловсролын газрын мэргэжилтэнтэй тус программыг нэвтрүүлэхтэй холбоотой цалингийн сангаас сургалтын зардалд 2.0 сая төгрөгийн гэрээ байгуулж, төсвийг зориулалт бус зарцуулсан. /Сүхбаатар аймгийн ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургууль 2.0 сая төгрөг/
- Төсвийг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулаагүй. /Мөнххаан сумын Засаг даргын Тамгын газар, Мөнххаан сумын цэцэрлэг, Сүхбаатар аймгийн ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургууль 17.2 сая төгрөг/
- Төсвийн хөрөнгийг зориулалт бус, үр ашиггүй зүйлд зарцуулсан /Мөнххаан сумын Засаг даргын Тамгын газар, Мөнххаан сумын Эрүүл мэндийн төв 5.7 сая төгрөг/
- Тээвэр шатахууны зарцуулалтад замын хуудсыг бүрэн, тодорхой, иж бүрэн хөтлөөгүй, дотоод хяналт сул, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулаагүй. /6 төсвийн шууд захирагч 39.0 сая төгрөг/
- Цалин, нэмэгдэл хөлс, урамшуулал буруу тооцож, олгосон. / 20 төсвийн шууд захирагч 21.8 сая төгрөг/
- Төрийн албанаас халагдсан төрийн албан хаагчийг Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр ажилд эргүүлэн томилж, ажилгүй байсан хугацааны цалин хөлсийг төсвөөс олгож, буруу шийдвэр гаргасан холбогдох этгээдээр буцаан төлүүлээгүй /Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газар, Халзан сумын Засаг даргын Тамгын газар 6.8 сая төгрөг/
- Өмнөх онуудад сумын иргэдэд ЭМГ-аас үзлэг, шинжилгээ хийлгэсний төлбөрийг цалингийн төсвөөс олгож /Засаг даргын нөөц сангаас гарах/, төсвийг зориулалт бус зарцуулсан. /Мөнххаан сумын Эрүүл мэндийн төв 6.1 сая төгрөг/
- Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд зарим албан хаагчдын цалин хөлсийг зөрүүтэй тайлагнасан /Эрдэнэцагаан сум Засаг даргын Тамгын газар, Эрдэнэцагаан сум Эрүүл мэндийн төв, Эрдэнэцагаан сум 2 дугаар цэцэрлэг, Уулбаян сумын Эрүүл мэндийн төв 6.5 сая төгрөг/

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаар тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Аймгийн Засаг даргын харьяа байгууллагуудын 2021 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зардлыг 81,225.5 сая төгрөгөөр төлөвлөж, баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд Засаг даргын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 81,225.5 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 59,110.4 сая төгрөгийг урсгал зардалд, 20,155.5 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 1,959.6 сая төгрөгийг эргэж төлөгдөх зээлд зарцуулахаар баталжээ.

Нийт зардлын 49,152.8 сая төгрөгийг улсын төсвөөс, 426.3 сая төгрөгийг Нийгмийн даатгалын сангаас, 26,333.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 5,313.2 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 48,878.6 сая төгрөгийг улсын төсвөөс, 255.0 сая төгрөгийг Нийгмийн даатгалын сангаас, 24,370.8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 2,836.8 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлого нийт 76,341.3 сая төгрөгийн санхүүжилтийг зарцуулж, орон нутгийн төсөвт 274.2 сая төгрөг, улсын төсөвт 739.4 сая төгрөг нийт 1,013.6 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилт:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сүхбаатар аймгийн Засаг даргын 2021 оны нэмэлт төсвийн гүйцэтгэлээр ЗДНХ, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 1,992.8, хандив тусламж 197.9, дээд шатны төсвийн захирагчаас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 1,784.2, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2,773.7 сая нийт 6,748.7 сая төгрөгийг зарцуулж, 218.2 сая төгрөгийг холбогдох дансанд төвлөрүүлж, 55.2 сая төгрөгийг Эрүүл мэндийн төвүүдийн харилцах дансанд үлдэгдэлтэй байна.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшилд 685.2, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 79.0, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 77.2, хангамж, бараа материалын зардалд 291.2, нормативд зардалд 1,007.9, эд хогшил, урсгал засварын зардалд 436.8, томилот, зочны зардалд 6.0, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 1,574.8, бараа үйлчилгээний бусад зардалд 1,749.8, урсгал шилжүүлэг 785.5 сая төгрөг нийт 6,693.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

3.7 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргасан.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.2-т заасны дагуу төсөв батлах, зарцуулах эрхийг гагцхүү аймгийн ИТХ-ын бүх төлөөлөгчдийн хурлын шийдвэрээр баталдаг. “Сүхбаатар хөгжил-ҮТП” ОНӨААТҮГ олон жил дамжсан өр төлбөртэй, үйл ажиллагааны орлогоор зардлаа нөхөж чаддаггүй нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан ЖДҮДС-ийн хөрөнгөөс зарцуулах эрхийг Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 07 тоот тогтоол гарч, олгосон. Уг сангийн хөрөнгө нь төсвийн нэг бүрэлдэхүүн хэсэг бөгөөд өөр зориулалтаар хөрөнгө зарцуулах тохиолдолд аймгийн ИТХ-аар төсвийг хэлэлцүүлэн, батлах ёстой. Гэтэл аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 07 тоот тогтоол гарч, сангийн зээлийн эргэн төлөлтөөс “Сүхбаатар хөгжил-ҮТП” ОНӨААТҮГ-ын 169.6 сая төгрөгийн өр төлбөрийг барагдуулж, үйл ажиллагаанд зарцуулах эрх олгосон нь Төсвийн тухай хуулийг зөрчиж, төсвийн хөрөнгийг зориулалт бус зарцуулсан байна.

Сүхбаатар аймгийн Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 13 төсвийн төвлөрүүлэн захирагч, 108 төсвийн байгууллага, 16 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 31 тусгай сан, 7 төсөл хөтөлбөр нийт 175 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 174 байгууллага аудитад хамрагдаж, 1 байгууллага аудитад хамрагдаагүй байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагаас 83 байгууллагыг түүвэрт хамруулж, 91 байгууллагад дүгнэлт хүргүүлээ. Үүнд: 76 байгууллагад “Зөрчилгүй”, 1 байгууллагад “Сөрөг” /Ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургууль/, 14 байгууллагад “Хязгаарлалттай”, дүгнэлт өгөв.

Хүснэгт № 11 “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн байгууллагууд

Д/Д	№	Аудитын код	Байгууллагын нэр
ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ			
1	1	СБА-2022/02/НА-СТА-ТТЗ	Баруун-Урт сумын Засаг дарга
2	2	СБА-2022/05/НА-СТА-ТТЗ	Мөнххаан сумын Засаг дарга
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ			
3	1	СБА-2022/67/НА-СТА-ТШЗ	Биеийн тамир спортын газар
4	2	СБА-2022/35/НА-СТА-ТШЗ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
5	3	СБА-2022/103/НА-СТА-ТШЗ	Баруун-Урт сумын 3 дугаар цэцэрлэг
6	4	СБА-2022/88/НА-СТА-ТШЗ	Баяндэлгэр сумын ерөнхий боловсролын сургууль
7	5	СБА-2022/95/НА-СТА-ТШЗ	Түмэнцогт сумын ерөнхий боловсролын сургууль

8	6	СБА-2022/40/НА-СТА-ТШЗ	Мөнххаан сумын ЗДТГ
9	7	СБА-2022/75/НА-СТА-ТШЗ	Мөнххаан сумын Эрүүл мэндийн төв
10	8	СБА-2022/80/НА-СТА-ТШЗ	Уулбаян сумын Эрүүл мэндийн төв
11	9	СБА-2022/81/НА-СТА-ТШЗ	Халзан сумын Эрүүл мэндийн төв
ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭД			
12	1	СБА-2022/03/НА-СТА-ОНА	Дөрвөлж ОНӨААТҮГ
13	2	СБА-2022/16/НА-СТА-ОНА	Уртын гэгээ ОНӨААТҮГ
14	3	СБА-2022/07/НА-СТА-ОНА	Сүхбаатар нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ

Аудитын илрүүлэлт

Сүхбаатар аймгийн Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар харьяа байгууллагуудад нийт 45,081.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 17,403.9 сая төгрөгийн алдааг залруулж, 325.9 сая төгрөгийн зөрчилд 68 төлбөрийн акт тогтоож, 4,402.3 сая төгрөгийн зөрчилд 137 албан шаардлага, 162.7 сая төгрөгийн 7 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлж, 22,786.3 сая төгрөгийн алдаа, зөрчилд 295 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Сүхбаатар аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн нийт 3,383.7 сая төгрөгийн дараах алдааг залрууллаа. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд 74.9 сая төгрөгөөр авлагыг илүү, 5.6 сая төгрөгөөр бараа материалыг илүү, 0.2 сая төгрөгөөр эргэлтийн бус хөрөнгийг илүү, 84.5 сая төгрөгөөр богино хугацаат өр төлбөрийг илүү, 462.2 сая төгрөгөөр эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/ илүү, 29.7 сая төгрөгөөр хуримтлагдсан үр дүн дутуу нэгтгэсэн
- Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд 15.5 сая төгрөгөөр татварын бус орлого илүү, 1,233.0 сая төгрөгөөр тусламж санхүүжилтийн орлогыг дутуу, 84.9 сая төгрөгөөр бараа үйлчилгээний зардал дутуу, 1,006.0 сая төгрөгөөр урсгал шилжүүлэг дутуу, 126.5 сая төгрөгөөр үйл ажиллагааны нийт үр дүн дутуу,
- Нэгтгэсэн цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайланд 9.8 сая төгрөгөөр нягтлан бодох бодлогын өөрчлөлтийг илүү, 16.1 сая төгрөгөөр өмчид гарсан өөрчлөлт илүү, 48.0 сая төгрөгөөр тайлант үеийн үр дүнг дутуу тайлагнасан;
- Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд 62.0 сая төгрөгөөр татварын бус орлогыг илүү, 7.4 сая төгрөгөөр тусламж санхүүжилтийн орлогыг илүү, 32.7 сая төгрөгөөр бараа үйлчилгээний зардлыг дутуу, 14.5 сая төгрөгөөр урсгал шилжүүлгийг илүү, нэгтгэсэн;
- Нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд 35.1 сая төгрөгөөр бараа үйлчилгээний бусад зардлыг илүү, 35.1 сая төгрөгөөр төсөвт байгууллагын өөрийн орлогыг илүү нэгтгэсэн:

3.8 Зөрчил дутагдлыг нэгж бүрээр нь авч үзвэл

Сүхбаатар аймгийн Засаг даргад хүргүүлсэн албан шаардлага

Сүхбаатар аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд 4,444.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 3,383.7 сая төгрөгийн алдааг залруулж, 169.6 сая төгрөгийн зөрчил дутагдлыг арилгах 3 албан шаардлага хүргүүлж, 891.6 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 7 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

3.8.1 Албан шаардлага:

3.8.1.1 Авлага, өр төлбөртэй холбоотой асуудал

Илрүүлэлт: ИТХ-ын тэргүүлэгчдийн 07 тоот тогтоол гарч, сангийн зээлийн эргэн төлөлтөөс “Сүхбаатар хөгжил-ҮТП” ОНӨААТҮГ-ын өр төлбөрийг барагдуулах, үйл ажиллагаанд зарцуулах эрх олгож 169.6 сая төгрөгийг зориулалт бус зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.2-т “*аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн шатны жилийн төсвийн төслийг хэлэлцэн жил бүрийн 12 дугаар сарын 05-ны дотор батлах;*” гэсэн заалт болон тайлант хугацааны ажил гүйлгээний анги, үйл явдал, холбогдох тодруулгатай холбоотой үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Уг зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх

3.8.1.2 Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант хугацаанд оруулбал зохих 61 мэдээллээс хугацаандаа оруулсан 51 мэдээлэл, хугацаа хоцроосон 10 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Уг зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх

3.8.1.3 Албан шаардлагын хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Өмнөх санхүүгийн тайлангаар олон жил болсон тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй зарим эзэн холбогдогч нь тодорхойгүй 105.5 сая төгрөгийн авлага, 324.7 сая төгрөг өр төлбөр, үлдэгдлээр тайлагнасан зөрчлийг арилгуулах албан шаардлага өгсөн боловч хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэх

Сүхбаатар аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар

Аудитаар нийт 8,305.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 8,179.5 сая төгрөгийн алдааг залруулж, 120.5 сая төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, зөрчлийн арилгах 6 албан шаардлага, 5.3 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 32 зөвлөмж өглөө.

Төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа төсвийн 108 байгууллагаас 40 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, Зөрчилгүй 57, Хязгаарлалттай 9, /Биеийн тамир спортын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Баруун-Урт сумын 3 дугаар цэцэрлэг, Баяндэлгэр сумын ЕБС, Түмэнцогт сумын ЕБС, Мөнххаан сумын ЗДТГ, Мөнххаан сумын ЭМТ, Уулбаян сумын ЭМТ, Халзан сумын ЭМТ/, сөрөг 1 /Сүхбаатар аймгийн ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургууль/ дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 23,853.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 9,072.1 сая төгрөгийн алдааг залруулж, 93.8 сая төгрөгийн зөрчилд 53 төлбөрийн акт тогтоож, 679.2 сая төгрөгийн зөрчилд 91 албан шаардлага, 162.7 сая төгрөгийн зөрчилд 6 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлж, 13,845.4 сая төгрөгийн алдаа, зөрчилд 226 зөвлөмж өглөө.

Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа орон нутгийн өмчит 16 аж ахуйн нэгж байгууллагаас 5 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, Зөрчилгүй 8, Хязгаарлалттай 3 /Дөрвөлж ОНӨААТҮГ, Сүхбаатар нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ, Уртын гэгээ ОНӨААТҮГ/ дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 10,741.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 131.5 сая төгрөгийн алдааг залруулж, 3.3 сая төгрөгийн зөрчилд 6 төлбөрийн акт тогтоож, 1,670.7 сая төгрөгийн зөрчилд 14 албан шаардлага, 8,935.6 сая төгрөгийн алдаа, зөрчилд 30 зөвлөмж өглөө.

Тусгай санд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа 31 тусгай сангаас 31 санхүүгийн тайланг түүвэрт хамрууллаа.

Аудитаар нийт 2,181.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 20.8 сая төгрөгийн алдааг залруулж, 108.3 сая төгрөгийн зөрчилд 6 төлбөрийн акт тогтоож, 2,052.4 сая төгрөгийн зөрчилд 26 албан шаардлага, 1 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 7 зөвлөмж өглөө.

3.9. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Сүхбаатар аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлант дараах анхаарал татахуйц асуудлууд байна.

- Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар биологийн хөрөнгө болох мал амьтадыг бодит үнэ цэнийн аргаар санхүүгийн тайланд толилуулах, ОНХС-аар хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлуудыг ЗДТГ-т бүртгэх бус тус санд нь захиалагчийн зүгээс бүртгэж байгаа байдлыг хамруулан авч үзэхээр төлөвлөж байна.
- Засаг даргын хүрээний байгууллагуудын аудитаар “Сөрөг”, “Хязгаарлалттай” дүгнэлт авсан байгууллагууд нь алдаа, зөрчлөө давтан гаргах, авлага, өр, төлбөрийг бууруулаагүй, санхүүгийн бүртгэл тайлагналыг сайжруулаагүй байх асуудлыг аудитаар авч үзэх нь зүйтэй байна.
- Цайртминерил ХХК-наас Жижиг дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор орон нутгийн төсөвт төвлөрүүлэх хөрөнгөөс олгосон 891.0 сая төгрөгийг данс бүртгэлд тусгаагүй байна.
- Аудит хамрагдаагүй 1 байгууллагыг завсрын аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

3.10 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГААС 2021-2022 ОНД ГҮЙЦЭТГЭХ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТАД БАРИМТЛАХ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛИЙН ХҮРЭЭНД АВЧ ҮЗСЭН АСУУДАЛ

1. Төсвийн зарцуулалт

Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн 9 арга хэмжээний хэрэгжилтэд аудитын горим, сорилыг хэрэгжүүлж ажиллаа.

Аудитаар 26 байгууллагад Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” журмын 1.2 /шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх;/, 1.4 /энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх;/, 1.5 /салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх;/ 1.6 /Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой,

урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх;/, дахь заалтуудыг тус тус зөрчиж 310.7 сая төгрөгийн зарцуулалт хийгдсэн байна.

Цаашид төсвийн хөрөнгийг захиран зарцуулалттай холбогдуулан гарсан Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын тушаал шийдвэрийг мөрдөж, батлагдсан төсвийг үр ашиг, арвилан хэмнэлттэй зарцуулах албан шаардлагыг зөрчил гаргасан шалгагдагч байгууллагад хүргүүлэв.

2. Коронавирус халдварт /ковид/-ын цар тахлын үед айл өрх, аж, ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай

Коронавирус халдварт /ковид/-ын цар тахлын үед айл өрх, аж, ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолын дагуу цэвэр, бохир усны хөнгөлөлт, чөлөөлөлтийн санхүүжилтийг Дөрвөлж ОНӨААТҮГ-аар дамжуулан олгосон байна. Нийт 856.7 сая төгрөгийн санхүүжилт авахаар нэхэмжилснээс 656.4 сая төгрөгийг авч сумдад 230.4 сая төгрөгийг олгосон. Санхүүгийн тайланд Эрчим хүчний яамнаас авах дулааны авлагыг 12,7 сая төгрөгөөр илүү илэрхийлснийг аудитаар илрүүлж, санхүүгийн тайланд залруулсан. Харин санхүүжилтийн үлдэгдэл 200.3 сая төгрөгийг тооцоо нийлж, баталгаажуулсан байна.

Уг үлдэгдлийн 43.4 сая төгрөг нь сумдад олгох хөнгөлөлт байна. Сумдад олгосон санхүүжилт нь оны эцэст олгогдож, зарцуулж чадаагүй бөгөөд авлага өр, төлбөрийг аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгүүлсэн байна.

3. Төрийн болон орон нутгийн өмчийн засаглал

Сүхбаатар аймгийн Засаг даргын нэгтгэсэн санхүүгийн тайланд 16 ОНӨААТҮГ-ын тайланд аудит хийлээ.

Хүснэгт № 12 ОНӨААТҮГ-ын үр дүн

№	Байгууллагын нэр	Хуримтлагдсан үр дүн	Тайлант үеийн үр дүн	Орон нутгаас санхүүгийн дэмжлэг
Ашигтай ажилласан ОНӨААТҮГ				
1	Дарьганга тохижилт ОНӨААТҮГ	1.4	29.6	
2	Онгон-Арвижих ОНӨААТҮГ	142.9	10.3	
3	Хайлааст голомт ОНӨААТҮГ	(95.6)	37.2	
4	Амгалант дэнж УТҮГ газар	16.1	16.1	8.6
5	Бичигт хөгжил ОНӨААТҮГ	5.9	5.9	39.0
6	Бичигт өргөө ОНӨААТҮГ	(236.4)	3.6	70.0
7	Халзан дулаан ОНӨААТҮГ	(43.7)	5.9	
	Хэсгийн дүн	(209.4)	108.6	
Ашиггүй ажилласан ОНӨААТҮГ				
8	Асгат улаан дэл ОНӨААТҮГ	2.9	(0.1)	-
9	Уртын гэгээ ОНӨААТҮГ	(243.2)	(194.1)	-
10	Нью Дарьганга ОНӨААТҮГ	(140.6)	(27.8)	-
11	Дөрвөлж ОНӨААТҮГ	(9,685.1)	(765.7)	-
12	Сүхбаатар нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ	(274.6)	(20.1)	-
13	Сүхбаатар ойжуулалт ОНӨААТҮГ	(112.0)	(29.6)	66.6
14	Сүхбаатар тохижилт үйлчилгээ-ОНӨААТҮГ	(9,679.5)	(42.1)	-
15	Сүхбаатар хөгжил ҮТПарк ОНӨААТҮГ	(301.7)	(64.9)	40.0
16	Түмэнцогт Ус дулаан ОНӨААТҮГ	(1,437.3)	(91.0)	-

17	Түмэнцогт ОНӨААТҮГ	(43.0)	(13.1)	-
18	Чоно хөгжил ОНӨААТҮГ	37.4	(14.0)	-
	Хэсгийн дүн		(1,262.5)	
	НИЙТ ДҮН	(22,086.3)	(1,153.9)	224.2

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант хугацаанд нийт дүнгээрээ 1,153.9 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Орон нутгийн төсвөөс санхүүжилт авдаггүй, өөрийн үйл ажиллагааны орлогоор зардлаа нөхдөг 6 байгууллага нийт байгууллагын 38.9 хувийг эзэлж байгаа бөгөөд 3.6-37.2 сая төгрөгийн ашигтай, 12 байгууллага буюу 61.1 хувь нь 0,1-765.7 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Дээрх аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудаас Бичигт хөгжил, Бичигт өргөө, Амгалант дэнж УТҮГ нь үйл ажиллагаа тогтмол явуулаагүй байна.

Эндээс дүгнэхэд орон нутгийн өмчит хуулийн этгээдээс өгөөж хүртэх байтал орон нутгийн төсвөөс 224.2 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон байна.

Аймгийн Засаг даргатай байгуулсан 6 ОНӨААТҮГ-ын гэрээний биелэлтийг дүгнэхэд 1 байгууллага хангалттай бусад 5 байгууллага хангалтгүй үнэлгээ авсан байна.

Хүснэгт № 12 ОНӨААТҮГ-ын үнэлэлт

№	Байгууллагын нэр	Хувь	Үнэлгээ
1	Амгалант дэнж УТҮГазар	54.3	Хангалтгүй
2	Дөрвөлж ОНӨААТҮГ	80.6	Хангалттай
3	Сүхбаатар нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ	54.3	Хангалтгүй
4	Сүхбаатар хөгжил УТПарк ОНӨААТҮГ	54.8	Хангалтгүй
5	Түмэнцогт Ус дулаан ОНӨААТҮГ	62.0	Хангалтгүй
6	Түмэнцогт ОНӨААТҮГ	59.9	Хангалтгүй

Орон нутгийн өмчит компаниудын ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, ил тод байдлыг хангасан засаглалыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлага байна. Тухайн зах зээлд үзүүлж буй үйлдвэрлэл, үйлчилгээг хувийн хэвшлээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх, төсвөөс санхүүгийн дэмжлэг авсан, үйл ажиллагаа оновчтой бус тодорхойгүй, ашиггүй ажилладаг орон нутгийн өмчит компаниудыг хувьчлах нь зүйтэй юм.

Мөн Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын засаглал, зорилго, үйл ажиллагаа, ялгаатай байдлыг тодорхойлох хууль эрх зүйн зохицуулалт дутагдаж байна.

4. Эрүүл мэндийн салбарын шинэчлэл

Эрүүл мэндийн, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулан 2020 оны наймдугаар сарын 28-ны өдөр Улсын Их Хурлын ээлжит бус чуулганаар баталсан. Уг хуулиудын хэрэгжилтийг хангах зорилгоор эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлийг 2021 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн хэрэгжүүлж эхэлсэн. Мөн эдгээр хуулийн нэмэлт өөрчлөлтөөр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зарцуулдаг улсын төсвийн санхүүжилтийг эрүүл мэндийн даатгалын санд нэгтгэн нэг худалдан авагчийн тогтолцоог бий болгосон байна. Үүнтэй холбоотойгоор аймгийн Засаг даргын харьяа 13 сумын өрхийн болон сумын ЭМТ-үүдийн нийт 110.4 сая төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг орон нутгийн төсвийн орлогын дансанд татан төвлөрүүлээгүй үлдэгдлээр тайлагнасан байна.

Засаг даргын харьяаны ЭМТ-н санхүүгийн тайлангийн аудитаар коронавирусын халдварын эсрэг цогц тусламж үйлчилгээ буюу шинжилгээний сорьц авах, гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээ, хэвтүүлэн эмчлүүлэх тусламж үйлчилгээ, дархлаажуулалтын

санхүүжилтийг холбогдох журмын дагуу олгосон, зарцуулсан эсэхэд аудитын горим сорилыг хэрэгжүүлэн ажиллав.

Аудитаар сум, өрхийн ЭМТ-үүд нь коронавирусын халдварын эсрэг цогц тусламж үйлчилгээний санхүүжилттэй холбоотой ЭМДС-аас нийт 1,121.1 сая төгрөгийн санхүүжилт авах тооцоо үүсэж, эм, эмчилгээний багц, халдвар хамгааллын хэрэгслийн зардлын нийт 170.6 сая төгрөгийн өр төлбөрийг тусгасан байна.

Аймгийн нэгдсэн эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлийг байгуулаагүйгээс тухайн жилд төсөв санхүүгийн талаарх эрх үүргээ хэрэгжүүлээгүй байна.

3.11. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 61 мэдээллээс хугацаандаа оруулсан 51 мэдээлэл, хугацаа хоцроосон 10 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэж байгаа боловч зарим мэдээллийг хангалтгүй байршуулсан гэж дүгнэлээ.

Аудитын илрүүлэлт:

Засаг даргын харьяаны байгууллагуудад шилэн дансны нэгдсэн сайтад оруулах мэдээллийг хуульд заасан хугацаанаас хоцроож, авлага, өр төлбөрийн тайлбар, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг мэдээлээгүй нийтлэг зөрчил дутагдал байна.

3.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Нийт 3 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмж хэрэгжих шатанд, 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

3.13. Аудитын зөвлөмж

1. Аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сан болон эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний зардлыг бүртгэхдээ тухайн сангуудын санхүүгийн байдлын тайлангийн дуусаагүй үйлдвэрлэл дансанд төсөл арга хэмжээ тус бүрээр дэд данс нээж холбогдох зардлыг хуримтлуулан бүртгэх ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлэх
2. Байгууллагуудын бүртгэлийг сайжруулж, дараагийн тайлангийн нэгтгэлийг хийхдээ Сангийн сайдын 2016 оны 12 сарын 16-ны өдрийн “Стандарт батлах тухай” 411 тоот тушаалын 1 дүгээр хавсралт “Биологийн хөрөнгө ба түүнээс хүлээн авсан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нягтлан бодох бүртгэлийн стандарт”-ын дагуу биологийн болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бүртгэлийг иж бүрэн нэвтрүүлж, алдааг байгууллага бүр дээр залруулж, төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах.

3. Төсөвт байгууллагын барилгад дулааны тоолуур суурилуулж, дулааны эрчим хүчний төлбөрийг Эрчим хүчний зохицуулах хорооны 2021 оны 10 сарын 14-ний өдрийн 461 дүгээр тогтоолоор батлагдсан “Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф”-ыг мөрдөж, Засгийн газрын 2020 оны 144 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж, төсвийн үр ашгийг дээшлүүлэх.
4. Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, засаглалыг сайжруулах зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэн, алдагдалтай ажиллаж байгаа, орон нутгийн төсвөөс санхүүгийн дэмжлэг авсан ч үйл ажиллагаа хэвийн явуулахгүй байгаа хуулийн этгээдэд төсвөөс санхүүгийн дэмжлэг олгохгүй байх зэргээр тодорхой ажлуудыг зохион байгуулах.
5. Төсвийн хэмнэлтийн талаар авч хэрэгжүүлж байгаа Засгийн газрын тогтоол шийдвэрийг орон нутагт мөрдүүлэх, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулахад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулахад анхаарч ажиллах
6. Өмнөх аудитаар өгөгдсөн бүрэн хэрэгжээгүй албан шаардлага, зөвлөмжүүдийн хэрэгжилтэд анхаарч ажиллах, үр дүнг эргэж мэдэгдэх;
7. Жижиг дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор олгосон 891.0 сая төгрөгийг данс бүртгэлд тусгаж, жил бүр тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

3.13. Холбогдох байгууллагын санал:



МОНГОЛ УЛС
СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас, факс: 70512121, 70518232

2022.05.04 № 1/406
танай _____-ны № _____-т

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Тайлбар, санал хүргүүлэх тухай

Сүхбаатар аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад дараах тайлбар, саналыг хүргүүлж байна. Үүнд:

1. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд 13 сумын ерөнхийлөн захирагчийн, 105 төсөвт байгууллагын, 19 ОНӨҮГ-ын, 32 төсөл сангийн зэрэг нийт 169 тайлан нэгтгэгддэг. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч болон ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн хувьд дээрх байгууллагуудын санхүү, төсвийн үйл ажиллагаанд өдөр тутмын хяналт тавих боломж хязгаарлагдмал учир эрсдэл өндөртэй байдаг. Ийм учраас алдаа зөрчлийн материаллаг байдлыг тайлангийн нийт хөрөнгийн 2 хувиар тооцуулах.

2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар **2,578,8** сая төгрөгийн материаллаг шинжтэй алдаа, зөрчил илэрснийг тайлагнасан байна. Үүнээс, дараах нөхцөл шалтгааны улмаас нийт **920,484.4** мянган төгрөгийг тайлант хугацааны материаллаг шинжтэй алдаа зөрчлөөс хасаж тооцуулах саналтай байна.

- Аймгийн ЗДТГ-ын санхүүгийн тайлангаар илэрсэн иргэн Б.Эрдэнэтуяа, Ү.Мөнхбат нарт шүүхийн шийдвэрийн дагуу олгосон **6,784,1** мянган төгрөгийн нөхөн олговрыг 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдөр олгосон бөгөөд тухайн онд буруутай этгээдээр нөхөн төлүүлэх цаг хугацааны боломж байгаагүй болно. 2022 онд буруутай этгээд нь төлөхөөр хүлээн зөвшөөрсөн.

- Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор “Сүхбаатар хөгжил ҮТП” ОНӨААТҮГ-аар дамжуулан олгосон зээлийн **891,600,0** мянган төгрөгийн **500,000,0** мянган төгрөг нь 2017 онд Цайртминерал ХХК, аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээнд тусгайлан зааснаар аймгийн төсвийн дансаар дамжиж төсвийн орлогоор бүртгэгдээгүй, 2 байгууллагын хооронд хийгдсэн гүйлгээ учир төсвийн тайланд авлагаар бүртгэх үндэслэлгүй болж байгаа юм. Энэ асуудлыг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн холбогдох шийдвэрийг гаргуулах, мөн аймгийн төсвийн данснаас шилжсэн 391,600,0 мянган төгрөгийг данс бүртгэлд тусгах ажлыг 2022 оны төсвийн жилд хэрэгжүүлэн ажиллана.

- Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 07 тоот тогтоол гарч “Сүхбаатар хөгжил ҮТП” ОНӨААТҮГ-ын шаардагдах санхүүжилтийг зээлийн эргэн төлөлт

2222100116

болон бусад эх үүсвэрээр шийдвэрлэх үүргийг аймгийн Засаг даргад өгснөөр **169,600,0** мянган төгрөгийг зарцуулсан байна. Энэ шийдвэрийн талаар танайхаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу ИТХ-д танилцуулж холбогдох шийдвэрийг гаргуулан зөрчлийг арилган ажиллана.

- 3 сумын "Сум хөгжүүлэх сан"-аас олгосон зээлийн хугацаандаа төлөгдөөгүй нийт **123,622,5** мянган төгрөгийн төлбөр нь тайлан тэнцэлд авлагаар тусгагдсан хүлээгдэж байгаа авлага юм. Холбогдох байгууллагад хандах болон бусад зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлж 2022 оны төсвийн жилд авлагыг бууруулан ажиллана.

- Дарьганга, Мөнххаан, Эрдэнэцагаан сумдын Малчин болон мал бүхий иргэдийн малын тоо толгойд ногдуулсан нийт **120,477,8** мянган төгрөгийн татварыг дутуу төвлөрүүлснийг материаллаг алдаа гэж үзсэн байна. Малын тоо толгойн албан татварын тухай хууль нь 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс хэрэгжиж эхэлсэн шинэ хууль, мөн Короновируст халдвар (Ковид-19) цар тахлын үед иргэдийн орлогыг хамгаалах зорилгоор 2021 оны 01 дүгээр сард Засгийн газрын хуралдаанаар тухайн татварыг 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хойшлуулах чиглэлийг аймаг, сумын ИТХ, ЗДТГ-т хүргүүлсэн зэргээс шалтгаалж энэ төрлийн орлогын бүрдүүлэлт хангалтгүй байсан. Гэсэн хэдийн татварын бүртгэлээр ногдуулалт нь бүртгэгдсэн байгаа учир нөхөн төлөгдөнө гэж үзэж байна.

3. Төсвийн байгууллагуудын болон ОНӨҮГ-уудын бусад алдаа зөрчлүүдийг хүлээн зөвшөөр байна.

Жил бүр Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг нэгтгэн төсвийн захирагчид болон нягтлан бодогчдод мэдээлэл хүргэж, зөрчлийг давтан гаргахгүй байх, анхаарч ажиллах асуудлын талаар сургалтаар болон албан тоотоор хүргүүлж ажилладаг хэдий ч алдаа зөрчил арилахгүй байна. Энэ нь нэг талаас тухайн ажил хариуцсан албан тушаалтнуудын мэдлэг, чадвар, ажилдаа хайнга, хариуцлагагүй хандаж байгаатай холбоотой, нөгөө талаас орон нутгийн засаг захиргааны тухайн асуудал хариуцсан нэгж, албад, төрийн хяналтын байгууллагууд хамтран тодорхой зорилго чиглэлтэй, судалгаа, шинжилгээн дээр үндэслэсэн даацтай арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах шаардлагатайг харуулж байна.

Байгууллагын болон хэлтсийн ажлын 2022 оны төлөвлөгөөнд санхүү, бүртгэлийн ажилтнуудын мэдлэг, мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр нэлээд ажлыг зохион байгуулахаар тусгасан бөгөөд эхний ажлууд хийгдээд байна.

Аудитын тайлангийн төсөлд тусгагдсан алдаа, зөрчлийг бууруулах, давтан гаргахгүй байх талаар та бүхэнтэй санал солилцон, асуудал боловсруулж хамтран үр дүнд хүрч ажиллах болно.

ЗАСАГ ДАРГА



М.ИДЭРБАТ

Холбогдох байгууллагын саналд өгсөн тайлбар:

Санхүүгийн аудитын тайлангийн төсөлд Засаг даргаас ирүүлсэн саналд санхүүгийн аудитын дүгнэлт, зөвлөмжийг хүлээн зөвшөөрсөн бөгөөд зарчмын зөрүүтэй зарим асуудалд тайлбар өгч байна. Үүнд:

- Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор Цайртминерал ХХК орон нутгийн захиргааны байгууллага аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу олгогдсон 891.6 сая төгрөг нь төсвийн нэг орлого тул тухайн санхүүжилтийн орлогыг данс бүртгэлд авлагаар тусгах нь зүйтэй гэж үзэж байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7.3 /хууль тогтоомжийн дагуу аймаг, нийслэлийн төсөвт төвлөрүүлэх бусад орлого/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.4.1 /аж ахуйн бүх гүйлгээ/, 14.4.2 /бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага/, 14.4.5 /бүх орлого/ гэсэн заалтууд бүрэн хангагдах юм.
- Жил бүрийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийг арилгах, зөвлөмж, албан шаардлагыг хүргүүлдэг боловч энэ талаар аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс дорвитой арга хэмжээ авдаггүй, нягтлан бодогч нарын мэдлэг дутмаг, төсөв захирагч нар тогтвор суурьшилтай ажилладаггүйг онцлон анхаарах нь зүйтэй.

3.14. АУДИТЫН ТАЙЛАН БАТАЛАГААЖУУЛСАН ТУШААЛ:



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2022 оны 05 сарын 04 өдөр

Дугаар А/07

Баруун-Урт сум

Аудитын тайланг баталгаажуулах
тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2018 оны А/207 тоот тушаалын 1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийж, дүгнэлт гаргасан санхүүгийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Тус аудитаар илрүүлсэн зөрчлийг арилгуулах албан шаардлага, зөвлөмжийг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланд тусгасан зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар авсан арга хэмжээ, түүний үр дүнг 2022 оны 8 дугаар сарын 30-ны дотор ирүүлэхийг аймгийн Засаг дарга /М.Идэрбат/-д даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *М.Нарантуяа* М.НАРАНТУЯА



D:/Bichig hereg/2022/tushaal

Тэргүүлэх аудиторын 2022 оны
04 сарын 29 өдрийн 225 дугаар
тушаалын хавсралт



СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2021 ОНЫ
ЖИЛИЙН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТААР
ХҮРГҮҮЛСЭН АЛБАН ШААРДЛАГА

№	Албан шаардлага хүргүүлсэн байгууллагын нэр	Албан шаардлагын дугаар	Мөнгөн дүн /сая төгрөг/	Хариуцсан аудитор
1	Сүхбаатар аймгийн Засаг дарга	153/A1740371	169.6	Н.Болдбаатар Б.Мөнхбамбар
2	Сүхбаатар аймгийн Засаг дарга	154/A1740371	-	Н.Болдбаатар Б.Мөнхбамбар
3	Сүхбаатар аймгийн Засаг дарга	155/A1740371	-	Н.Болдбаатар Б.Мөнхбамбар
Нийт дүн			169.6	

3.15. ХҮРГҮҮЛСЭН АЛБАН ШААРДЛАГА



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 05 сарын 04 өдөр

Дугаар 153 А-4420371

Баруун-Урт сум

СБА-2022/01/НА-СТА-ТЭЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Сүхбаатар аймгийн Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд: Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 07 тоот тогтоол гарч, сангийн зээлийн эргэн төлөлтөөс "Сүхбаатар хөгжил-ҮТП" ОНӨААТҮГ-ын өр төлбөрийг барагдуулах, үйл ажиллагаанд зарцуулах эрх олгож 169.6 сая төгрөгийг зориулалт бус зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.2-т "аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн шатны жилийн төсвийн төслийг хэлэлцэн жил бүрийн 12 дугаар сарын 05-ны дотор батлах;" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана." гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоолоор төсөв захиран зарцуулах зөрчилтэй шийдвэр гаргах явдлыг таслан зогсоож, ЖДҮДС-ийн зээлийг төсвийн нэгэн бүрэлдэхүүн болгож, жилийн бүрийн төсвийн төсөлтэй хамт батлуулан, зарцуулалт, үр ашигт нь хяналт тавьж ажиллахыг Сүхбаатар аймгийн Засаг дарга М.Идэрбат, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Д.Ариунжаргал нарт даалгав.
2. Албан шаардлагын биелэлтийг 2022 оны 8 дугаар сарын 30-ны дотор Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх
3. Төлбөрийн акт, албан шаардлага хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д заасны дагуу хариуцлага тооцно.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.НАРАНТУЯА





СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 05 сарын 04 өдөр

Дугаар 154 А 1740371

Баруун-Урт сум

СВА-2022/01/НА-СТА-ТЭЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Сүхбаатар аймгийн Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд: Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 61 мэдээллээс хугацаандаа оруулсан 51 мэдээлэл, хугацаа хоцроосон 10 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 / тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;/ 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4 дэх заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т " Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана." гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны мэдээллийг хуульд заасан хугацаанд үнэн зөв, иж бүрэн олон нийтэд ойлгомжтой мэдээлж, биелэлтийг 2022 оны 8 дугаар сарын 30-ны дотор Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Сүхбаатар аймгийн Засаг дарга М.Идэрбат, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Д.Ариунжаргал нарт даалгав.
3. Төлбөрийн акт, албан шаардлага хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д заасны дагуу хариуцлага тооцно.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.НАРАНТУЯА





СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 05 сарын 04 өдөр

Дугаар 155

#1740321

Баруун-Урт сум

СБД 2022/161 НА-СТА -763

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Сүхбаатар аймгийн Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд: Өмнөх санхүүгийн тайлангаар олон жил болсон тооцоо нийлсэн актаар баталгаажгаагүй зарим эзэн холбогдогч нь тодорхойгүй 105.5 сая төгрөгийн авлага, 324.7 сая төгрөг өр төлбөр, үлдэгдлээр тайлагнасан зөрчлийг арилгуулах албан шаардлага өгсөн боловч хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай 42 дугаар зүйлийн 42.1 /Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно./- заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т " Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана." гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хангалтгүй хэрэгжүүлсэн Сүхбаатар аймгийн СТСХ-ийн дарга /Д.Ариунжаргал/-д холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах,
2. Албан шаардлагын биелэлтийг 2022 оны 8 дугаар сарын 30-ны дотор Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх
3. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Сүхбаатар аймгийн Засаг дарга М.Идэрбат, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Д.Ариунжаргал нарт даалгав.
4. Төлбөрийн акт, албан шаардлага хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д заасны дагуу хариуцлага тооцно.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.НАРАНТУЯА



4.1 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Төсвийн захирагчийн ангилал	Нийт зөрчил		Залруулсан		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох санал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТЕЗ	30	4,444,900.0	20	3,383,700.0	0	0	2	169,600.0	7	891,600.0	1	
ТТЗ	68	8,305,309.2	27	8,179,531.4	3	120,477.8	6		32	5,300.0		
ТШЗ	413	23,853,178.6	37	9,072,075.3	53	93,804.2	91	679,206.0	226	13,845,419.1	6	162,674.0
ОНТС	42	2,181,540.8	2	20,776.3	6	108,338.4	26	2,052,426.1	7		1	
ОНӨААТҮГ	58	10,741,128.0	8	131,468.7	6	3,318.7	14	1,670,739.3	30	8,935,601.3		
	611	49,526,056.6	94	20,787,551.7	68	325,939.1	139	4,571,971.4	302	23,677,920.4	8	162,674.0

4.2 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

Хавсралт №2

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
1	ТЕЗ	1	1	-	-	-	1	-	-
2	ТТЗ	13	13	-	-	11	2	-	-
3	ТШЗ	108	67	40	1	57	9	1	-
4	БСД	7	-	7	-	-	-	-	-
5	ОНТС	31	-	31	-	-	-	-	-
6	ОНӨААТҮГ	16	11	5	-	8	3	-	-
		176	92	83	1	76	15	1	-